



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 27/564

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрлийн  
хугацааг сунгах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Адрага сумын нутаг дэвсгэрт орших “Их Барчгайт” нэртэй 203.57 гектар талбай бүхий “Күүпермен” ХХК-ийн XV-23000051 дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг хоёр жилээр сунгасугай.

2.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан тухай ашигт малтмал, газрын тосны болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, тус аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Мөнх-Эрдэнэ), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Б.Сүнгээ)-т тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ